



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

Г СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ПҮРЭВДОРЖИЙН БАТ-ОЧИР ТАНАА

2020-09-03 № СОТ-2020/06-НД-Б  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Сайхан sumaас бие даан нэр дэвшигч Пүрэвдоржийн Бат-Очирэн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд Сайхан sumaас бие даан нэр дэвшигч П.Бат-Очир нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


## Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч П.Бат-Очирын Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч П.Бат-Очирын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2020 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ПҮРЭВДОРЖИЙН БАТ-ОЧИРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

4317143998  
МЮА0065 9055436

### **1. ХҮНИЙ ХӨГЖИЛ**

- Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан хүүхдийн боловсрол, мэдлэгийг хөгжүүлэх зорилгоор “Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв” байгуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц ур чадвартай, оюунлаг, урлаг спортын өндөр чадамжтай төгсөгчдийг бэлтгэн гаргахыг зорин ажиллана.
- Эрүүл мэндийн салбарын оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн, иргэд орон нутагтаа тусlamж, үйлчилгээг бүрэн авах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Өрх, гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг судлан өрхийн үйлдвэрлэлийн шинэ салбарыг хөгжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг дэмжих бодлого баримталж ажиллана.

### **2. ЭДИЙН ЗАСАГ**

- Төрөөс иргэдэд үзүүлэх нэгдсэн үйлчилгээг цахим ухаалаг системд тулгуурлан хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт технологийн дэвшил, бусад нөөц бололцоог ашиглах боломжийг холбогдох бусад байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- Жижиг дунд үйлдвэрлэл, дэд бүтэц, тээвэр логистик, хөдөө аж ахуйг хөгжүүлэх төслүүдийг орон нутагтаа хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.
- Баялаг бүтээгч хувийн хэвшил, хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

### **3. НИЙГЭМ**

- Ард иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцөлд анхаарч, орон нутагтаа камерын хяналт, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, хог хаягдал, орчны тохижилтын ажлыг шинэчлэн сайжруулахад санаачилгатай ажиллана.
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт нэмэгдүүлнэ.
- Сум, орон нутгийн урт ба дунд, богино хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

- Сум орон нутгийн хил, бүсчлэлийн асуудлыг хуулийн хурээнд шийдвэрлүүлж, дэд бүтцэд тулгуурласан өөрчлөлтийг хийхэд нийт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана.



Бие даан нэр дэвшигч *Бат-Очир* П.Бат-Очир

2020.07.24